

**ЭРЧИМ ХҮЧНИЙ АУДИТОР, ЭРЧИМ ХҮЧНИЙ АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН
ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ҮНЭЛЭХ АРГАЧЛАЛ**

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. Эрчим хүчний аудитор (цаашид “аудитор” гэх), Эрчим хүчний аудитын байгууллага (цаашид “аудитын байгууллага” гэх) нь холбогдох хууль, журмын шаардлагыг ханган ажиллаж байгаа эсэхэд хяналт тавих, хариуцлагыг дээшлүүлэх, тэдгээрийн үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор жилийн үйл ажиллагааг үнэлж, дүгнэхэд энэхүү аргачлалыг мөрдөнө.

1.2. Үнэлж, дүгнэх үйл ажиллагаанд хууль дээдлэх, шударга, хөндлөнгийн аливаа нөлөөллөөс ангид хараат бус, үр дүнд чиглэсэн, бодит тоо баримт, нотолгоонд тулгуурлах зарчмыг баримтална.

ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ

2.1. Аудитор, аудитын байгууллагын үйлчилгээний чанар, тэдгээрийн үйл ажиллагааг үнэлэх ажлыг дараах хүрээнд явуулна.

2.1.1. Аудиторын үйл ажиллагаа

2.1.1.а. Аудитын тайлангийн чанар, стандартын нийцлийн үнэлгээ

2.1.1.б. Аудитор тавих шаардлага, холбогдох хууль, журмын нийцлийн үнэлэгээ

2.1.2. Аудитын байгууллагын үйл ажиллагаа

2.1.2.а. Магадлан итгэмжлэл эзэмшигчид тавих шаардлага, холбогдох хууль, журмын нийцлийн үнэлгээ

2.1.2.б. Аудитын тайлангийн чанар, стандартын нийцлийн үнэлгээ

2.1.3.в. Мэргэжлийн үйлчилгээтэй холбоотой зохион байгуулалт, гүйцэтгэлийн үнэлгээ

**ГУРАВ. ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,
МЭДЭЭ ТАЙЛАН ХҮЛЭЭН АВАХ, ҮНЭЛЭХ**

3.1. Энэ аргачлалын 1.1-д заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн акт, MNS EN 16247:2017 стандартыг удирдлага болгоно.

3.2. Үнэлгээний хамрах хүрээ, үзүүлэлтээс хамаарч энэ аргачлалын хавсралт маягтын дагуу мэдээллийг хүлээн авах, бүртгэх, үнэлэх, мэдээллийн сан үүсгэх зэрэг ажлыг тухайн асуудлыг хариуцсан мэргэжилтэн хийж гүйцэтгэнэ.

3.3. Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий нэгжийн дарга энэ аргачлалын дагуу мэдээллийг хүлээн авах, үнэлэх үйл ажиллагаанд үйл ажиллагаанд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллана.

3.4. Аудитор, аудитын байгууллагын жилийн үйл ажиллагааны үнэлгээний нэгдсэн дүнг дараа жилийн нэгдүгээр улиралд багтаан ЭХЗХ-ны хуралд танилцуулж дүнг баталгаажуулна.

3.5. Аудитор, аудитын байгууллагын үнэлгээнд хамаарах тайлан, холбогдох мэдээ, баримт, материалыг Засгийн газрын 2019 оны 181 дүгээр тогтоолоор баталсан “Эрчим хүчний аудит хийх журам”, “Эрчим хүчний аудитын байгууллага болон эрчим хүчний мэргэжлийн байгууллагад тавих шаардалага, тэдгээрийг магадлан итгэмжлэх журам”-д тус тус заасан хугацаанд хавсралт маягтын дагуу гаргаж цахимаар/бичгээр Эрчим хүчний зохицуулах хороонд ирүүлсэн нөхцөлд үнэлнэ. Үүнд:

3.5.1. Жилийн үйл ажиллагааны тайланг /Хавсралт-1/ загварын дагуу дараа жилийн нэгдүгээр сард.

3.5.2. Аудитын мэдээг /Хавсралт-2/ маягтын дагуу хэрэглэгчтэй гэрээ байгуулснаас хойш 14 хоногийн дотор тухай бүр.

3.5.3. Гүйцэтгэсэн аудитын мэдээг /Хавсралт-3/ маягтын дагуу үйлчлүүлэгчид аудитын тайланг хүлээлгэн өгч гэрээг дүгнэснээс хойш 14 хоногийн дотор тухай бүр.

3.5.4. Үүрэг хүлээсэн хэрэглэгчээс ирүүлсэн аудитын тайланг /Хавсралт-4/ маягтын дагуу тухай бүр.

3.5.5. Аудитын үйл ажиллагаатай холбоотой үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгааг /Хавсралт-5/ маягтын дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 1 сарын дотор.

ДӨРӨВ. ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

4.1. Аудитын байгууллагын жилийн үйл ажиллагааг дараах үндсэн 3 үзүүлэлтээр үнэлнэ.

4.1.1. Аудитын тайлангийн чанар, стандартын нийцлийг хавсралт 4-д заасан маягтын дагуу үнэлэх бөгөөд жилийн үйл ажиллагааны үнэлгээнд эзлэх хувийн жин 50 хувь байна.

4.1.2. Магадлан итгэмжлэл эзэмшигчид тавих шаардлага, холбогдох хууль, журмын нийцлийг хавсралт 6-д заасан маягтын дагуу үнэлэх бөгөөд жилийн үйл ажиллагааны үнэлгээнд эзлэх хувийн жин 30 хувь байна.

4.1.3. Мэргэжлийн үйлчилгээтэй холбоотой зохион байгуулалт, гүйцэтгэлийн үзүүлэлтийг хавсралт 7-д заасан маягтын дагуу үнэлэх бөгөөд жилийн үйл ажиллагааны үнэлгээнд эзлэх хувийн жин 20 хувь байна.

4.2. Аудиторын жилийн үйл ажиллагааг дараах үндсэн 2 үзүүлэлтээр үнэлнэ.

4.2.1. Аудитын тайлангийн чанар, стандартын нийцлийг хавсралт 4-д заасан маягтын дагуу үнэлэх бөгөөд жилийн үйл ажиллагааны үнэлгээнд эзлэх хувийн жин 50 хувь байна.

4.2.2. Аудитор тавих шаардлага, холбогдох хууль, журмын нийцлийг хавсралт 6-д заасан маягтын дагуу үнэлэх бөгөөд жилийн үйл ажиллагааны үнэлгээнд эзлэх хувийн жин 50 хувь байна.

4.3. Энэ аргачлалын 4.1, 4.2-т заасан үзүүлэлт тус бүрд харгалзах нийт авсан оноог тухайн үзүүлэлтийн авбал зохих оноонд харьцуулж хувиар илэрхийлнэ.

$$YXO = \frac{1}{n} \sum_{k=1}^n \left(\frac{AY_k}{AZ_k} \right) 100\%$$

YXO - Үзүүлэлт бүрд харагалзах оноо

AY - Авсан оноо

AZ - Авбал зохих оноо

n - Шалгуур үзүүлэлтийн тоо

k - Шалгуур үзүүлэлтийн дугаар

4.4. Аудитор, аудитын байгууллагын жилийн үйл ажиллагааг дараах байдлаар үнэлнэ.

Гүйцэтгэл (%)	Үнэлгээ
91-ээс 100 хүртэл	Хангалттай сайн
76-аас 90 хүртэл	Сайн
61-ээс 75 хүртэл	Дунд
60-аас доош	Хангалтгүй

ТАВ. ҮР ДҮНГ МЭДЭЭЛЭХ, ТАЙЛАГНАХ, МЭДЭЭЛЛИЙН САН ҮҮСГЭХ

5.1. Үнэлгээний нэгдсэн тайлан, танилцуулгыг энэ аргачлалын 3.4-д заасан хугацаанд ЭХЗХ-ны хуралд танилцуулна.

5.2. Үнэлгээний тайланд тулгуурлан гаргасан шийдвэрийг үндэслэн аудитор, аудитын байгууллагын үйл ажиллагаатай холбоотой дутагдал зөрчлийг арилгах, чанар, үр дүнг сайжруулахад шаардлагатай арга хэмжээний санал, зөвлөмжийг аудитор, аудитын байгууллагад хүргүүлж үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.

5.3. Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу үнэлгээний тайлан, нэгдсэн дүгнэлтийн талаарх сонсох үйл ажиллагааг жил бүрийн 2 дугаар сард багтаан аудитор, аудитын байгууллагуудад явуулж, Хорооны хурлдаар хэлэлцэхээс өмнө тайлан, мэдээллийг залруулах, сайжруулах боломжоор хангаж болно.

5.4. Засгийн газрын 2019 оны 181 дүгээр тогтоолоор баталсан “Эрчим хүчний аудитын байгууллага болон эрчим хүчний мэргэжлийн байгууллагад тавих шаардлага, тэдгээрийн магадлан итгэмжлэх журам”-ын 6 дугаар зүйлийн 6.6-д заасны дагуу аудитор, аудитын байгууллагын үйл ажиллагааны үнэлгээний дүн, нэгдсэн мэдээллийг Хорооны веб сайтаар дамжуулан олон нийтэд мэдээлнэ.

ЗУРГАА. ХАВСРАЛТ, МАЯГТУУД

- 6.1. Хавсралт-1. Жилийн үйл ажиллагааны тайлангийн загвар.
- 6.2. Хавсралт-2. Аудитын урьдчилсан мэдээний маягт.
- 6.3. Хавсралт-3. Гүйцэтгэсэн аудитын мэдээний маягт.
- 6.4. Хавсралт-4. Аудитын тайлан үнэлэх маягт.
- 6.5. Хавсралт-5. Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгааны маягт.

6.6. Хавсралт-6. Холбогдох хууль, журмын шаардлага, тэдгээрийн нийцлийг үнэлэх маягт.

6.7. Хавсралт-7. 4.2. Мэргэжлийн үйлчилгээтэй холбоотой зохион байгуулалт, гүйцэтгэлийн үзүүлэлтийг үнэлэх маягт.

*Эрчим хүчний аудитор, аудитын байгууллагын
жилийн үйл ажиллагааг үнэлэх аргачлалын нэгдүгээр хавсралт*

**АУДИТОР/АУДИТЫН БАЙГУУЛЛАГА /...../-ЫН ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

ХҮЛЭЭН АВСАН:

Аудитор бол:

Эрчим хүч хэмнэлтийн газрын

Аудитор менежерийн сургалт хариуцсан мэргэжилтэн:

Магадлан итгэмжлэгдсэн байгууллага бол:

Тус газрын нэгдсэн бодлогын хэрэгжилт хариуцсан ахлах мэргэжилтэн:

Овог нэг:...../...../

Он сар өдөр:.....

ТАНИЛЦСАН/ХЯНАСАН:

Аудитор/ Аудитын байгууллагын удирдлага/ Аудитын багийн ахлагч

1. Овог нэр /...../

БОЛОВСРУУЛСАН.

1. Эрчим хүчний аудитор..... /...../

2.

20 ... он

Жилийн үйл ажиллагааны тайлангийн загвар

Товч агуулга:

Аудитор, аудитын байгууллагын товч танилцуулга, тайлант онд хийж гүйцэтгэсэн үйл ажиллагааны талаарх хураангуй мэдээллийг энд бичнэ.

1. ҮЙЛ АЖИЛЛАГАА:

- *Олгосон эрх, магадлан итгэмжлэлийн хүрээнд явуулсан үндсэн үйл ажиллагааны талаарх ерөнхий мэдээлэл;*
- *Эрчим хүч хэмнэлтийн чиглэлээр хэрэгжүүлсэн бусад үйл ажиллагааны талаарх ерөнхий мэдээлэл*

2. КОМПАНИЙ ЗАСАГЛАЛЫН ТАЛААР /Бие даасан аудиторт хамаарахгүй/:

- *Байгууллагын бүтэц, зохион байгуулалт, аудиторуудын ур чадвар, ажлын туршлага, тэдгээрийн мэргэжлийн үйл ажиллагаанд үзүүлж буй хувь нэмэр*
- *Байгууллагын алсын хараа, жилийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлсэн байдал*
- *Мэргэжлийн үйлчилгээнд тулгарч буй саад бэрхшээл, ололт амжилт, цаашдын эргэлзээтэй асуудлууд, түүнийг сайжруулах боломж*

3. АУДИТОРУУДЫН УР ЧАДВАР, ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧАДАВХЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ, БАЙГУУЛЛАГЫН ЧАДАМЖИЙН ТАЛААР:

- *Аудиторууд сургалтад хамрагдсан байдал*
- *Бусад мэргэжилтэй боловсон хүчний сургалт, хөгжил*
- *Аудитын үйл ажиллагаанд ашиглаж буй программ хангамж, хэмжих багаж хэрэгсэл, тэдгээрийг сайжруулсан тухай*
- *Эрчим хүчний зохицуулах хорооноос зохион байгуулсан бусад арга хэмжээнд оролцсон байдал*

4. ХУУЛЬ, ЖУРАМ, СТАНДАРТЫН ХЭРЭГЖИЛТ, ХОРООНООС ӨГСӨН ЗӨВЛӨМЖ, ЧИГЛЭЛ, ТЭДГЭЭРИЙН БИЕЛЭЛТ:

- *Олгосон эрх, магадлан итгэмжлэлийн хүрээнд тавигдах шаардлагууд зохих ёсоор мөрдөгдөж байгаа эсэх*
- *Хорооноос өгсөн зөвлөмж, үүрэг даалгаврын биелэлт*
- *Нэмэлт тодруулга, тайлбар*

5. ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ:

6. ДАРАА ЖИЛИЙН ЗОРИЛТ:

Жич: Жилийн үйл ажиллагааны тайланг аргачлалын 3.5.1-д заасны дагуу жил бүрийн нэгдүгээр сард багтааж бичгээр/цахимаар ирүүлнэ. Аудитор, аудитын байгууллага нь холбогдох баримт, нэмэлт мэдээллийг тайланд хавсаргаж ирүүлж болно.

Эрчим хүчний аудитор, аудитын байгууллагын
жилийн үйл ажиллагааг үнэлэх аргачлалын хоёрдугаар хавсралт

АУДИТЫН МЭДЭЭ

Засгийн газрын 2019 оны 181 дүгээр тогтоолоор баталсан “Эрчим хүчний аудит хийх журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.4, 2 дугаар зүйлийн 2.1, 2.2, 3 дугаар зүйл, 4 дүгээр зүйлийн 4.1-дэх заалтыг тус тус удирдлага болгов.

Үйлчлүүлэгчийн мэдээлэл		
Хуулийн этгээдийн нэр:		
Хуулийн этгээдийн хаяг, байршил:		
Хуулиар үүрэг хүлээсэн хэрэглэгч мөн эсэх:	Тийм / Үгүй	
Эрчим хүч хэмнэлтийн менежер эсхүл тухайн асуудал хариуцсан холбогдох ажилтны мэдээлэл:	Нэр:	
	Албан тушаал:	
	Утас:	
	Имэйл:	
Аудитор/ Аудитын байгууллагын мэдээлэл		
Аудитын байгууллагын нэр:		
Холбоо барих утас, Имэйл:		
Аудитын багийн ахлагчийн нэр:		
Үйлчилгээ үзүүлэх аудиторууд:	Аудитын чиглэл	Аудиторын нэр
	Цахилгаан	Овог, нэр
	Дулаан/ уур	Овог, нэр
	Барилга	Овог, нэр
Эрчим хүчний аудитын үйлчилгээний мэдээлэл		
Аудитын гэрээний дугаар:		
Аудитын гэрээний хугацаа:		
Гүйцэтгэх аудитын төрөл:	Анхан шатны /Хэсэгчилсэн/ Дэлгэрэнгүй аудит “Аудит хийх журам”-ын 3.2/ 3.3/ 3.4	
Аудитын үйлчилгээний хамрах хүрээ:	Ажлын даалгаврын дагуу аудит хийх алба, хэлтэс, нэгж, цех, технологийн процесс	
Аудит хийсэн объектын хаяг, байршил:		

Баталгаажуулсан:

Аудитор/ Аудитын байгууллагын удирдлага/ Аудитын багийн ахлагч

..... (нэр, гарын үсэг, тамга)

Хүлээн авсан:

Эрчим хүчний зохицуулах хорооны Эрчим хүч хэмнэлтийн газрын

Аудитор менежерийн сургалт хариуцсан мэргэжилтэн:

Эсхүл нэгдсэн бодлогын хэрэгжилт хариуцсан ахлах мэргэжилтэн:

Овог нэг:...../...../

Он сар өдөр:.....

Жич. Энэхүү Аудитын мэдээнд аудитын гэрээ, аудит хийх төлөвлөгөө, ажлын даалгаврын хуулбарыг хавсаргаж ирүүлнэ.

ГҮЙЦЭТГЭСЭН АУДИТЫН МЭДЭЭ

Засгийн газрын 2019 оны 181 дүгээр тогтоолоор баталсан “Эрчим хүчний аудит хийх журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.4, 2 дугаар зүйлийн 2.1, 2.2, 3 дугаар зүйл, 4 дүгээр зүйлийн 4.1, 5 дугаар зүйлийн 5.2.7-д заалтыг тус тус удирдлага болгов.

Аудитын тайлангийн мэдээлэл	
Аудитын тайлан, зөвлөмжийг үйлчлүүлэгчид тайлагнаж танилцуулсан эсэх	Тийм, Огноо 20... оны ... сарын ... өдөр Үгүй
Аудитын тайлан, зөвлөмжийг үйлчлүүлэгчид хүлээлгэн өгсөн огноо	20... оны ... сарын ... өдөр
Аудитын тайланг боловсруулж хүлээлгэн өгсөн	
Аудитын байгууллагын нэр	
Холбоо барих утас, Имэйл	
Аудитын багийн ахлагч, аудитор, бусад ажилтнууд	Нэр : _____ Утас: _____ (гарын үсэг, тамга) Бусад ажилтнууд Нэр : _____ Утас: _____ (гарын үсэг, тамга)
Эрчим хүчний аудитын үйлчилгээний мэдээлэл	
Байгууллагын удирдлага	Нэр : _____ Утас: _____ Албан тушаал: _____ (гарын үсэг, тамга)
Эрчим хүчний хэмнэлт, үр ашгийн асуудлыг хариуцах газар, хэлтсийн удирдлага	Нэр : _____ Утас: _____ Албан тушаал: _____ (гарын үсэг, тамга)
Эрчим хүч хэмнэлтийн менежер эсхүл холбогдох ажилтан	Нэр : _____ Утас: _____ Албан тушаал: _____ (гарын үсэг, тамга)

Баталгаажуулсан:

Аудитор/ Аудитын байгууллагын удирдлага/ Аудитын багийн ахлагч

..... (нэр, гарын үсэг, тамга)

Хүлээн авсан:

Эрчим хүчний зохицуулах хорооны Эрчим хүч хэмнэлтийн газрын

Аудитор менежерийн сургалт хариуцсан мэргэжилтэн:

Эсхүл нэгдсэн бодлогын хэрэгжилт хариуцсан ахлах мэргэжилтэн:

Овог нэг:...../...../

Он сар өдөр:.....

Жич. Энэхүү Гүйцэтгэсэн аудитын мэдээнд аудитын гэрээ дүгнэсэн актыг хавсаргаж ирүүлнэ

ЭРЧИМ ХҮЧНИЙ АУДИТЫН ТАЙЛАН ҮНЭЛЭХ МАЯГТ

Засгийн газрын 2019 оны 181 дүгээр тогтоолоор баталсан “Эрчим хүчний аудит хийх журам”, “Үүрэг хүлээсэн хэрэглэгчийг тодорхойлох, ҮХХ-ийн эрчим хүч хэмнэх хөтөлбөр, төлөвлөгөө, тэдгээрийг боловсруулах аргачлал, хэрэгжилтийг тайлагнах журам”-ын 5 дугаар зүйлийн 5.3 дах заалт, Эрчим хүчний аудитын MNS EN 16247:2017 стандартыг тус тус удирдлага болгов.болгов.

Хуулийн этгээдийн нэр: Аудитор/ аудитын байгууллага:

Үнэлгээ: Тийм бол-1, үгүй бол-0

№	Шалгуур		Аудитын төрөл	
			анхан шатны	Хэс/дэлгэр энгүй
1	Ерөнхий хэсэг		3	3
	1.1	Гарчиг	1	1
	1.2	Товчилсон ү, хүснэгт, зураг, графикийн жагсаалт	1	1
	1.3	Хавсралт	1	1
2	Танилцуулга хэсэг		3	3
	2.1	Хураангуй	1	1
	2.2	Үр ашгийг сайжруулах боломжыг эрэмбэлсэн байдал	1	1
	2.3	Санал болгож буй хөтөлбөр/арга хэмжээг тодорхойлох	1	1
3	Үндэслэл хэсэг		5	5
	3.1	Аудит хийсэн байгууллагын танилцуулга	1	1
	3.2	Аудиторуудын танилцуулга, хэн аль хэсгийг гүйцэтгэсэн тухай мэдээлэл	1	1
	3.3	Аудитын зорилго	1	1
	3.4	Аудит хийсэн объект, хэсгийн танилцуулга	1	1
	3.5	Ашигласан норм, дүрэм, журам, стандартын тухай	1	1
4	Эрчим хүчний аудит		4	7
	4.1	Төрөл, хамрах хүрээ, нарийвчлал, хугацаа, төлөвлөгөө	1	1
	4.2	Өгөгдөл мэдээлэл цуглуулсан байдал	1	1
	4.3	Хэмжилт хийх шаардлага, нөхцөл байдал	-	1
	4.4	Хэмжилт хийсэн мэдээлэл, утгуудын талаарх мэдээлэл	-	1
	4.5	Хэмжилт хийсэн багаж төхөөрөмжийн баталгаажуулалт, тохирлын гэрчилгээний талаарх мэдээлэл/хуулбар	-	1
	4.6	Өгөгдөл, мэдээлэл, хэмжилтэд хийсэн дүн шинжилгээ	1	1
	4.7	Үр ашгийг сайжруулах арга хэмжээний эрэмбийг тодорхойлсон шалгуур үзүүлэлтүүд	1	1
5	Эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх боломж		4	6
	5.1	Санал болгож буй арга хэмжээ, хэрэгжүүлэх төлөвлөгөө	1	1
	5.2	Тооцоонд ашигласан таамаглал, зөвлөмжийн нарийвчлал	1	1
	5.3	Санхүүжилт, хөрөнгө оруулалтын мэдээлэл/татаас, зээл	1	1
	5.4	Эдийн засгийн үр өгөөжийн талаарх тооцоо, дүгнэлт	-	1
	5.5	Санал болгож буй арга хэмжээний уялдаа хамаарал	-	1
	5.6	Зөвлөмжийг хэрэгжүүлснээр гарах хэмнэлтийг тодорхойлсон тооцооны арга, аргачлалын тухай	-	1
	5.7	Дараагийн аудит, нарийвчилсан хэмжилт, судалгаа хийх шаардлагыг тодорхойлсон байдал	1	-
6	Ерөнхий дүгнэлт		1	1
НИЙТ ОНОО			20	25

Тайланг хүлээн авч үнэлсэн:

Эрчим хүчний зохицуулах хорооны ЭХХГ-ын

ҮХХ хариуцсан мэргэжилтэн:

Овог нэг:...../...../

Он сар өдөр:.....

Үнэлгээг хянаж, баталгаажуулсан:

Эрчим хүчний зохицуулах хорооны

ЭХХГ-ын дарга:

Овог нэг:...../...../

Он сар өдөр:.....

ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГАА

Засгийн газрын 2019 оны 181 дүгээр тогтоолоор баталсан “Эрчим хүчний аудит хийх журам”-ын 5 дугаар зүйлийн 5.1.7, “Эрчим хүчний аудитын байгууллага болон мэргэжлийн байгууллагад тавих шаардлага, тэдгээрийг магадлан итгэмжлэх журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.4.3 дах заалтыг тус тус удирдлага болгов.

Мэдээлэл

Аудитын үйлчилгээ авсан байгууллагын нэр:

Үйлчилгээ үзүүлсэн аудитор, байгууллагын нэр:

Эрчим хүч хэмнэлтийн менежер эсхүл эрчим хүчний хэмнэлт, үр ашиг хариуцсан ажилтны мэдээлэл Овог нэр: Албан тушаал:
Утас: Имэйл:

Аудитын гэрээний хугацаа

Аудитын төрөл *Анхан шатны / Хэсэгчилсэн/ Дэлгэрэнгүй*

Аудитын үйлчилгээний хамрах хүрээ *Хэсэг, нэгж, цех, технологийн процесс*

1. Аудитын үйлчилгээний чанар, мэргэшлийн түвшин, ур чадвар

Үнэлгээ: *Маш сайн-3, Сайн-2, Дунд-1, Хангалтгүй-0*

Үнэлэх үзүүлэлтүүд	Оноо
1. Ажлын байранд үзлэг хийж, тодруулга, ярилцлага авсан байдал	
2. Хэмжих хэрэгсэл ашиглан хэмжилт, туршилт хийсэн байдал	
3. Өгөгдөл мэдээлэл, хэмжилтийн үр дүнг боловсруулж, дүгнэсэн байдал	
4. Боловсруулсан зөвлөмж нь үндэслэл, нотолгоонд суурилсан эсэх, түүнийг боловсруулсан байдал	
5. Аудитын үйлчилгээ үзүүлэхээр санал болгосон аудиторуудын оролцоо, тэдгээрийн оролцсон байдал	
6. Үр дүн, тайлан, зөвлөмжийг танилцуулсан байдал	
7.а. <u>Анхан шатны аудит</u> - Шууд хэрэгжүүлэх арга хэмжээ, цаашид нарийвчилсан судалгаа хийх хэрэгцээ шаардлага, ажлын цар хүрээг тодорхойлсон байдал	
7.б. <u>Хэсэгчилсэн, дэлгэрэнгүй аудит</u> - Шаардлагатай хөрөнгө оруулалт, түүний өгөөжийг тооцоолсон байдал	
8. Аудитын баг бүрэн бүрэлдэхүүнээрээ ажилласан эсэх	
9. Аудиторын ёс зүй, харилцааны ур чадвар	
10. Ажлын даалгавар бүрэн биелсэн эсэх	

2. Санал, шүүмж

Аудитын байгууллага/аудиторын үзүүлсэн аудитын үйлчилгээнд цаашид сайжруулах зүйлс болон санал, шүүмж байгаа бол тодорхой бичнэ үү.

Судалгаанд оролцсон:

Ажилтны нэр, албан тушаал:/Гарын үсэг/

Судалгаа авсан:

Эрчим хүчний зохицуулах хорооны Эрчим хүч хэмнэлтийн газрын

ҮХХ хариуцсан мэргэжилтэн:

Эсхүл, аудито, менежерийн сургалт хариуцсан мэргэжилтэн

Овог нэг:/Гарын үсэг/

Он сар өдөр:

Жич. Энэхүү судалгааг аудитын үйлчилгээний чанарыг үнэлэх зорилгоор Эрчим хүчний зохицуулах хорооноос авч байгаа бөгөөд эрчим хүчний аудитор/аудитын байгууллагын жилийн үйл ажиллагааг үнэлэхэд судалгааны дүнг харгалзан авч үзнэ. Судалгаанд оролцох хүний тоог хязгаарлаагүй болно.

ХОЛБОГДОХ ХУУЛЬ, ЖУРМЫН ШААРДЛАГА, ТЭДГЭЭРИЙН НИЙЦЛИЙГ ҮНЭЛЭХ МАЯГТ

Засгийн газрын 2019 оны 181 дүгээр тогтоолоор баталсан “Эрчим хүчний аудит хийх журам”-ын 5 дугаар зүйлийн 5.2.8, “Эрчим хүчний аудитын байгууллага болон мэргэжлийн байгууллагад тавих шаардлага, тэдгээрийг магадлан итгэмжлэх журам”-ын 6 дугаар зүйлийн 6.5, 7 дугаар зүйлийн 7.1, 7.2 дах заалтыг тус тус удирдлага болгов.

Үнэлгээ: Тийм бол-1, үйгүй бол-0

№	Шалгуур	Оноо	
		Аудитын байгууллага	Аудитор
1	Магадлан итгэмжлэлийн төрөл, олгосон эрхийн хүрээнд үйл ажиллагаа явуулсан байх	3	1
	1.1 Магадлан итгэмжлэлийн төрлийн хүрээнд үйл ажиллагаа явуулсан байх	1	-
	1.2 Олгосон эрхийн хүрээнд аудит хийсэн байх	-	1
	1.3 Аудитын ажилд харьяагдаж буй аудиторуудын оролцоо бүрэн хангагдсан байх	1	-
2	Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль, бусад хууль тогтоомжийн биелэлт	2	2
	2.1 Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан аудитор, аудитын байгууллагын эрх, үүрэгтэй холбоотой зөрчил гарсан эсэх	1	1
	2.2 Аудитор, аудитын байгууллагын үйл ажиллагаанд мөрдвөл зохих бусад хууль тогтоомжийг мөрдсөн эсэх /хөдөлмөрийн харилцаа, татвар, НД гэх мэт/	1	-
3	Магадлан итгэмжлэл эзэмшигчид тавих шаардлага, тэдгээрийн нийцэл	7	5
	3.1 Хүний нөөцөд тавигдах шаардлага хангагдсан байх	1	-
	3.2 Аудиторууд бусад байгуулагад аудитороор хавсран, хослон ажил эрхэлдэггүй байх	1	-
	3.3 Аудитор, инженер, техникийн ажилтнуудыг жилд 1-ээс удаа сургалтад хамруулсан байх	1	1
	3.4 Программ хангамж, хэмжүүрийн болон бусад багаж хэрэгслийн бүрдэлтэй байх	1	1
	3.5 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөрчил гаргаагүй байх	1	1
	3.6 Мэргэжлийн ёс зүй, үйлчилгээний чанартай холбоотой гомдол маргаан гарсан эсэх, түүнийг шийдвэрлэсэн эсэх	1	1
	3.7 Тайлан мэдээллийг тогтоосон хугацаанд ирүүлсэн эсэх	-	1
4	Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлөөс өгсөн үүрэг даалгавар, зөвлөмж чиглэлийг биелүүлсэн эсэх	-	1
5	Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааны үр дүн /Жич:Энэ хэсэгт үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгаагаар авбал зохих 30 оноог бүрэн авсан бол харгалзах оноог бүрэн авсан гэж үзнэ/	-	2
Нийт оноо		10	10

Үнэлсэн:

Эрчим хүчний зохицуулах хорооны ЭХХГ-ын

Сургалт хариуцсан эргэжилтэн:

Эсхүл ахлах мэргэжилтэн:

Овог нэг:...../...../

Он сар өдөр:.....

Үнэлгээг хянаж, баталгаажуулсан:

Эрчим хүчний зохицуулах хорооны

ЭХХГ-ын дарга:

Овог нэг:...../...../

Он сар өдөр:.....

**МЭРГЭЖЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭТЭЙ ХОЛБООТОЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,
ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙГ ҮНЭЛЭХ МАЯГТ**

Засгийн газрын 2019 оны 181 дүгээр тогтоолоор баталсан “Эрчим хүчний аудит хийх журам”-ын 5 дугаар зүйлийн 5.2.8, “Эрчим хүчний аудитын байгууллага болон мэргэжлийн байгууллагад тавих шаардлага, тэдгээрийг магадлан итгэмжлэх журам”-ын 6 дугаар зүйлийн 6.5, 7 дугаар зүйлийн 7.1, 7.2 дах заалтыг тус тус удирдлага болгов.

Аудитын байгууллагын нэр:

Үнэлгээ: Тийм бол-1, үйгүй бол-0

№	Шалгуур	Оноо
1	Тайлан мэдээллийг тогтоосон хугацаанд ирүүлсэн байх	3
	1.1 Жилийн үйл ажиллагааны тайланг тогтоосон ирүүлсэн эсэх	1
	1.2 Аудитын мэдээг ирүүлсэн эсэх	1
	1.3 Гүйцэтгэсэн аудитын мэдээг ирүүлсэн эсэх	1
2	Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлөөс өгсөн үүрэг даалгавар, зөвлөмж, чиглэлийн биелүүлсэн эсэх	1
3	Сэтгэл ханамжийн судалгааны үр дүн /Жич:Энэ хэсэгт үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгаагаар авбал зохих 30 оноог бүрэн авсан бол харгалзах оноог бүрэн авсан гэж үзнэ/	5
4	Жилийн үйл ажиллагааны тайлангийн чанар, үр дүнгээс хамаарч 5 хүртэл оноо өгнө	5
Нийт оноо		15

Үнэлгээг хянаж, баталгаажуулсан:

Эрчим хүчний зохицуулах хорооны ЭХХГ-ын дарга

Овог нэг:...../...../

Он сар өдөр:.....

Үнэлгээ хийсэн:

Эрчим хүчний зохицуулах хорооны Эрчим хүч хэмнэлтийн газрын

Нэгдсэн бодлогын хэрэгжилт хариуцсан ахлах мэргэжилтэн:

Овог нэг:...../...../

Он сар өдөр:.....